ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ХЭА-2022/60/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чингис хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар<br>Утас: 70562112<br>Аудитын менежер: Д.Оюунтуяа<br>Утас: 99775390<br>Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:<br>Аудитор: Б.Маналсүрэн<br>Утас: 99059424 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....... 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 3
3. Аудитын тайлан ....... 4
3.1 Ерөнхий зүйл ....... 4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 4
3.4 Материаллаг байдал ....... 5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....... 7
3.8 Аудитын гол асуудал ....... 7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 7
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 8
4. Аудитын илрүүлэлт ....... 8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....... 9

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.23 № 310

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ГАНГАНТӨГС ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

023087492

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

СТ-1А

Баянмөнх сумын цэцэрлэг

**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

**2021 оны 12 дугаар сарын 31** /Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **29,478,265.52** | **29,597,565.52** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **33** | **АВЛАГА** | 1,611,746.00 | 1,611,746.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,611,746.00 | 1,611,746.00 |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | - | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | - | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 27,866,519.52 | 27,985,819.52 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| 35130 | Эм боох материал | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 27,866,519.52 | 27,985,819.52 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35420 | Аж ахуйн материал | 6,984,575.00 | 6,984,575.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | - |
| 35450 | Барилгын засварын материал | 1,514,100.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 1,832,000.00 | 2,786,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,535,844.52 | 18,214,644.52 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **416,838,372.53** | **1,032,844,380.58** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 416,838,372.53 | 1,032,844,380.58 |
| **392** | **Биет хөрөнгө** | 408,588,372.53 | 1,024,594,380.58 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 384,190,140.00 | 1,012,064,354.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,298,853.86) | (19,990,204.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 38,903,727.00 | 38,903,727.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (9,355,990.72) | (14,277,990.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,929,000.00 | 11,929,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,222,094.84) | (10,129,619.92) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,034,950.00 | 5,034,950.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,372,694.91) | (2,720,024.85) |
| 39217 | Ном | 3,780,189.86 | 3,780,189.86 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,250,000.00 | 8,250,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,250,000.00 | 8,250,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **446,316,638.05** | **1,062,441,946.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **446,316,638.05** | **1,062,441,946.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 446,316,638.05 | 1,062,441,946.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 8,250,000.00 | 8,250,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 8,250,000.00 | 8,250,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 31,376,080.48 | 647,501,388.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 31,376,080.48 | 31,376,080.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 616,125,308.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22,021,989.07 | 22,021,989.07 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **446,316,638.05** | **1,062,441,946.10** |

Баянмөнх сумын цэцэрлэг

# АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**2021 оны 12 дугаар сарын 31** /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **217,949,110.00** | **819,917,714.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,986,810.00** | **627,874,214.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,986,810.00 | 627,874,214.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,986,810.00 | 627,874,214.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,986,810.00 | 627,874,214.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **211,962,300.00** | **192,043,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 194,917,100.00 | 175,272,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 194,917,100.00 | 175,272,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 119,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 109,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 10,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 17,045,200.00 | 16,651,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 17,045,200.00 | 16,651,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **209,411,034.74** | **203,792,405.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **209,411,034.74** | **203,792,405.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 199,563,325.80 | 202,138,647.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 132,060,606.57 | 138,242,136.25 |
| 210101 | Үндсэн цалин | 80,807,054.65 | 75,035,024.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,180,375.26 | 38,894,713.08 |
| 210104 | Урамшуулал | 8,962,799.66 | 10,352,099.25 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 11,110,377.00 | 13,960,299.92 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,823,498.34 | 18,245,978.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,439,899.75 | 13,621,242.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,345,899.73 | 1,156,034.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,076,699.96 | 925,067.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 269,199.77 | 230,966.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,691,799.13 | 2,312,668.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,307,336.15 | 16,166,156.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,373,970.77 | 2,079,016.29 |
| 210302 | Түлш, халаалт | 12,934,000.00 | 13,267,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 999,365.38 | 820,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,017,250.00 | 2,231,420.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 484,000.00 | 74,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 499,850.00 | 499,620.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 752,000.00 | 752,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 36,000.00 | 39,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 540,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,705,400.00 | 625,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 16,072,550.00 | 11,188,650.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,000.00 | 36,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,197,550.00 | 11,152,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 840,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 485,000.00 | 1,999,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210604 | Урсгал засвар | 485,000.00 | 1,999,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 66,000.00 | 66,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 66,000.00 | 66,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 324,000.00 | 324,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 324,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,407,084.74 | 13,675,205.95 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,500.00 | 96,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,071,900.00 | 1,711,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,249,684.74 | 11,868,205.95 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,847,708.94 | 1,653,758.82 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,447,708.94 | 243.71 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,447,708.94 | 243.71 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,353,515.11 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,353,515.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **8,538,075.26** | **616,125,308.05** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 602,261.19 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 602,261.19 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (602,261.19) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **7,935,814.07** | **616,125,308.05** |

CT-4A

Баянмөнх сумын цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**2021 оны 12 дугаар сарын 31** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 392,918,568.50 | 22,021,989.07 | 23,440,266.41 | 438,380,823.98 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **392,918,568.50** | **22,021,989.07** | **23,440,266.41** | 438,380,823.98 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 7,935,814.07 | 7,935,814.07 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **392,918,568.50** | **22,021,989.07** | **31,376,080.48** | 446,316,638.05 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **392,918,568.50** | **22,021,989.07** | **31,376,080.48** | 446,316,638.05 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **392,918,568.50** | **22,021,989.07** | **31,376,080.48** | 446,316,638.05 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 616,125,308.05 | 616,125,308.05 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **392,918,568.50** | **22,021,989.07** | **647,501,388.53** | 1,062,441,946.10 |

Баянмөнх сумын цэцэрлэг

# АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**2021 оны 12 дугаар сарын 31** /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **211,962,300.00** | **192,043,500.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **211,962,300.00** | **192,043,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 194,917,100.00 | 175,272,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 194,917,100.00 | 175,272,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 119,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 109,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 10,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 17,045,200.00 | 16,651,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 17,045,200.00 | 16,651,400.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **199,162,300.00** | **192,043,500.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **199,162,300.00** | **192,043,500.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **189,314,591.06** | **190,389,741.18** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 132,060,606.57 | 138,242,136.25 |
| 210101 | Үндсэн цалин | 80,807,054.65 | 75,035,024.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,180,375.26 | 38,894,713.08 |
| 210104 | Урамшуулал | 8,962,799.66 | 10,352,099.25 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 11,110,377.00 | 13,960,299.92 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,823,498.34 | 18,245,978.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,439,899.75 | 13,621,242.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,345,899.73 | 1,156,034.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,076,699.96 | 925,067.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 269,199.77 | 230,966.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,691,799.13 | 2,312,668.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,433,336.15 | 16,166,156.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,373,970.77 | 2,079,016.29 |
| 210302 | Түлш, халаалт | 12,060,000.00 | 13,267,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 999,365.38 | 820,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,134,250.00 | 2,231,420.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,064,000.00 | 74,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 499,850.00 | 499,620.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 752,000.00 | 752,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 36,000.00 | 39,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 540,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,242,400.00 | 625,700.00 |
| **2105** | **Норматив зардал** | 14,151,500.00 | 12,492,050.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,000.00 | 36,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,389,700.00 | 12,106,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,726,800.00 | 348,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 485,000.00 | 485,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210604 | Урсгал засвар | 485,000.00 | 485,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 66,000.00 | 66,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 66,000.00 | 66,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 324,000.00 | 324,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,836,400.00 | 2,137,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,500.00 | 96,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,750,900.00 | 2,041,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,847,708.94** | **1,653,758.82** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,447,708.94 | 243.71 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,447,708.94 | 243.71 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,353,515.11 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,353,515.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,800,000.00** | **-** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,800,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,800,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,800,000.00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | 12,800,000.00 | - |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | - | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(12,800,000.00)** | **-** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

Баянмөнх сумын цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**2021 оны 12 дугаар сарын 31** **/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 191,924,000.00 | 190,570,241.18 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 191,924,000.00 | 190,570,241.18 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 191,624,000.00 | 190,270,241.18 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 138,257,900.00 | 138,242,136.25 |
| 210101 | Үндсэн цалин | 86,694,500.00 | 75,035,024.00 |
| 210102 | Нэмэгдэл | 27,251,000.00 | 38,894,713.08 |
| 210104 | Урамшуулал | 10,352,100.00 | 10,352,099.25 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,960,300.00 | 13,960,299.92 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,452,000.00 | 18,245,978.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,979,200.00 | 13,621,242.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,368,200.00 | 1,156,034.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,094,600.00 | 925,067.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 273,600.00 | 230,966.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,736,400.00 | 2,312,668.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,166,200.00 | 16,166,156.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,007,000.00 | 2,079,016.29 |
| 210302 | Түлш, халаалт | 13,159,200.00 | 13,267,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 820,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,112,900.00 | 2,111,920.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 64,600.00 | 64,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 499,620.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 752,400.00 | 752,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 39,500.00 | 39,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутг | 240,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 516,400.00 | 516,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,622,600.00 | 12,492,050.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,300.00 | 36,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,237,500.00 | 12,106,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 348,800.00 | 348,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 485,200.00 | 485,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 485,200.00 | 485,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 66,100.00 | 66,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 66,100.00 | 66,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа** | 324,000.00 | 324,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,137,100.00 | 2,137,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,000.00 | 96,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,041,100.00 | 2,041,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 300,000.00 | 300,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 300,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 191,924,000.00 | 190,570,241.18 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 175,272,600.00 | 173,919,084.89 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 175,272,600.00 | 173,919,084.89 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 16,651,400.00 | 16,651,156.29 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 16,651,400.00 | 16,651,156.29 |

**НТ-2**

Баянмөнх сумын цэцэрлэг

**АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

**2021 оны 12 дугаар сарын 31** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **119,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **119,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 119,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 119,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 10,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 109,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 119,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 119,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 109,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 10,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор Б.Баярмаа, аудиторын туслах Б.Мөнхзул нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянмөнх сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:"Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино" гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурийн хөтлөж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаа сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 209,411.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,094.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.675.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 1,630.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 616,125.3 мянган төгрөгөөр буюу 138 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 1,611.7 | 1,611.7 | - |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 27,866.5 | 27,985.8 | 119.3 |
| Үндсэн хөрөнгө | 416,838.4 | 1,032,844.4 | 616,006.0 |
| **Нийт хөрөнгө** | **446,316.6** | **1,062,441.9** | **616,125.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 392,918.6 | 392,918.6 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 31,376.0 | 647,501.3 | 616,125.3 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22,022.0 | 22,022.0 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **446,316.6** | 1,062,441.9 | 616,125.3 |

Бараа материалын дансны үлдэгдэл нь 27,985.8 мянган төгрөг болж 119.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 14,807.5 мянган төгрөгийн бараа материал

худалдан авч 14,688.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,032,844.4 мянган төгрөг болж 616,006.0 мянган төгрөгөөр өссөн нь 627,874.2 мянган төгрөгийн барилга байгууламж шилжүүлэн авсан байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 11,868.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогджээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 647,501.3 мянган төгрөг болж, 616,125.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлтөөс нөлөөлсөн байна.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 601,968.6 мянган төгрөгөөр буюу 276.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт 19,644.5 мянган төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй авсан орлого 621,887.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 5,618.6 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл хангамж бараа материалын зардал 1,785.8 мянган төгрөгөөр, нормативт зардал 4,883.9 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 323,847.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 131,923.8 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 191,924.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин,нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 28,731.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 42,613.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,112.5 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 35,657.2 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 191,924.0 мянган төгрөгөөр баталсанаас 175,272.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 16,651.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 175,272.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 16,651.4 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 190,570.2 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 1,353.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 0.3 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 190,570.2 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 15.7 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 130.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 119.5 мянган төгрөгийн орлого орж, 119.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

## 3.8 Аудитын гол асуудал

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх онд итгэл үзүүлж, аудит хийгдээгүй болно.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,592.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,592.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.**

*Илрүүлэлт:*

4.4.1.Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 1,592.4 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Баянмөнх сумын цэцэрлэг | 1 | 1,592.4 | | | | | | | 1 | 1,592.4 |
| Дүн | | 1 | 1,592.4 | | | | | | | 1 | 1,592.4 |